



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/395

Мандалговь


Албан тушаалын тодорхойлолт  
батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалт, "Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2016 оны 9 дүгээр тогтоолын 4 дэх заалт, "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-ын 5.1 дэх заалт, "Зөвшөөрөл олгох тухай" Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 63 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


Нэг. Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Биеийн тамир, спортын газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Боловсрол, соёл, урлагийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Орон нутгийн өмчийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Эрүүл мэндийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

Хоёр. Батлагдсан албан тушаалын тодорхойлолтыг дээрх агентлагийн дарга нарын үйл ажиллагаанд мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), холбогдох хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ



488191115



**МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2019 оны 9 сарын 13 өдөр

Дугаар 63

Улаанбаатар хот

**Зөвшөөрөл олгох тухай**

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, "Аймгийн засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2016 оны 9 дүгээр тогтоолын 4 дэх заалт, "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-ын 4.1, 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим хэрэгжүүлэгч агентлагийн даргын албан тушаалын тодорхойлолтыг хянан хэлэлцээд **ТОГТООХ** нь:


1.Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Биеийн тамир, спортын газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Боловсрол, соёл, урлагийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Орон нутгийн өмчийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Эрүүл мэндийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар хавсралт ёсоор тус тус батлахыг Аймгийн Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.

2.Хянаж зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолт тус бүрийг албажуулах, баталж мөрдүүлэх, нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагааг мэргэшил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Б.Алтанзул/-нд даалгасугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ



Дундговь аймгийн Засаг даргын  
2019 оны 11 дүгээр сарын 5 -ны өдрийн  
1395 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Дундговь аймгийн Байгаль орчин,  
аялал жуулчлалын газар

Нэгжийн нэр:

Албан тушаалын нэр:

Байгаль орчин, аялал жуулчлалын  
газрын дарга

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ахлах түшмэл, ТЗ-10

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Ажлын байрны албан ёсны байршил:

Дундговь аймгийн Сайнцагаан сум, 7 дугаар  
баг, Буяаннэмэхийн өргөн чөлөө 1-105 тоот

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хууль тогтоомжийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, аймгийн Засаг дарга болон нутгийн захиргааны байгууллагуудыг бодлогын зөвлөгөө, мэдээллээр хангаж, мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлэх, чиг үүргийн хүрээнд агентлагийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг аймгийн Засаг даргын өмнө хариуцан тайлагнана.

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

.....аймгийн  
Байгаль орчин, аялал жуулчлалын  
газар

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Байгаль орчин, аялал жуулчлалын  
газрын дарга

Ахлах түшмэл, ТЗ-10

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдөр 8 цаг

.....аймгийн  
.....сумын.....баг

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:


Хэвийн

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хууль тогтоомжийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, аймгийн Засаг дарга болон нутгийн захиргааны байгууллагуудыг бодлогын зөвлөгөө, мэдээллээр хангаж, мэргэшил арга зүйн дэмжлэг



үзүүлэх, агентлагийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг аймгийн Засаг даргын өмнө хариуцан тайлагнана.

Албан тушаалын зорилт:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын төрийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах.
2. Байгалийн нөөц баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглуулах.
3. Байгаль орчин, аялал жуулчлалын мэдээллийн сан бүрдүүлэх, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах.
4. Төсвийн шууд захирагчийн хувьд байгууллагын төсвийн хөрөнгийг удирдах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай захиран зарцуулах, тайлагнах.
5. Газрын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1. Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр батлагдсан байгаль орчин, аялал жуулчлалын салбарын бодлогын баримт бичиг, хөтөлбөр, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт байгалийн нөөц баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулах,</p> <p>2. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр гаргасан зарлигийг орон нутагт хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг хангах,</p> <p>3. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын дүрэм, журам, стандартыг мөрдүүлэх, сурталчилах, хэрэгжилтэд хяналт тавих.</p> <p>4. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан байгаль орчин, аялал жуулчлалын бодлогыг орон нутагт төлөөлөн</p>	<p>Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана.</p>	<p>Х,Г</p> <p>Х,Г</p> <p>Х,Г</p>

Бүртгэлийн дугаар ...410.....

**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

**ХУУЛБАР ҮНЭН**

Хуулбар олгосон албан хаагчийн гарын үсэг

*[Signature]*

2019 оны 11 сарын 06 нөхдөгч өдөр



	<p>хэрэгжүүлэх, гэрээнд тусгагдсан тодорхой арга хэмжээг хариуцан зохион байгуулах,</p> <p>5.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн болон усны нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх замаар санхүүгийн баталгаатай эх үүсвэрийг бий болгож, эдгээр хөрөнгөөр орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулж, хэрэгжилтийг хангуулах,</p> <p>6.Байгаль орчин, аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулах.</p> <p>7.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах, аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа болон шинээр эхлэх төслүүдийг үнэлгээнд хамруулах, аж ахуйн нэгж, байгууллагуудын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилттэд хяналт тавих, хуулийн дагуу эрх үүргийнхээ хүрээнд гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтийн талаарх тайланг жил бүр Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд танилцуулж байх,</p> <p>8.Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг хангах зорилгоор ногоон орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, энэ ажилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүч оролцоо, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах,</p>	<p>Г</p> <p>Х, Г</p> <p>Г</p> <p>Х, Г</p> <p>Г</p>
<p>2 дугаар зорилтын хүрээнд</p>	<p>1.Байгаль орчныг хамгаалах ажилд иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог өргөжүүлж, тэдний санал, хүсэлт, мэдээллийг хүлээн авч хэрэгжүүлэх арга хэмжээ авах,</p> <p>2.Ой, ус, ургамал, амьтан зэрэг байгалийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг орон нутагт зохион байгуулах,</p>	<p>Х,Г</p> <p>Х,Г</p>



Бүртгэлийн дугаар ... 411 ...

**ДУНДГОВЬ АЙМГИЙН**  
**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**  
**ХУУЛБАР ҮНЭН**  
Хуулбар олгосон бичигтний гарын үсэг

*[Signature]*

2019 оны 11 сарын 06 өдөр

<p>3.Байгаль орчныг доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх, халгүй хаягдалгүй цэвэр технологи нэвтрүүлэх, инновацийг хөгжүүлэх, урамшуулах ажлыг зохион байгуулах,</p>	<p>Хууль тогтоомжид заасны дагуу аймгийн хүн ам эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх хангагдана.</p>	<p>Х,Г</p>
<p>4.Орон нутгийн хэмжээнд ой, ус, ургамал, амьтан зэрэг байгалийн нөөц хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд үнэлгээ хийх, ан агнуурын менежмент төлөвлөгөөг хангуулах ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах,</p>		<p>Х,Г</p>
<p>5.Тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх,</p>		<p>Х,Г</p>
<p>6.Аймгийн ойн сангийн ой зохион байгуулалтыг явуулж, өөрчлөлтийг тооцон мэдээлэх, ойн ашиглалт, хамгаалалтын бүс, хот суурин газрын ногоон бүсийг тогтооход санал өгөх, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд ойн санг эзэмшүүлэх, ашиглуулах талаар баримт материал бүрдүүлэх, гэрээ байгуулах, батламжлуулахад мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний хэрэгжилтэд технологийн хяналт тавьж, зөрчлийг арилгуулах,</p>		<p>Х,Г</p>
<p>7.Бүс нутгийн байгаль орчинд зохицсон, зохих материаллаг бааз бүхий модлог ургамлын үржүүлгийн газар байгуулж, тарьц, суулгац ургуулах, мод сөөгийн үрийн нөөцийн сан бүрдүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах замаар сайн чанарын үр, тарьц суулгац бэлтгэж орон нутгийн хэрэгцээг хангах.</p>		<p>Х,Г</p>
<p>8.Мод бэлтгэх талбай тусгаарлах, мод бэлтгэлийн ажилд технологийн хяналт тавьж, мод бэлтгэсэн талбайг хүлээн авах, мод модон материал, түүхий эд бэлтгэдэг мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулж, техник технологийн түвшинд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах, зах зээлд чанар сайтай модон материал нийлүүлэх явдлыг дэмжих замаар хууль бусаар мод бэлтгэх явдлыг</p>	<p>Байгаль, орчны талаар гарсан хууль тогтоомж бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангасан байна.</p>	<p>Х,Г</p>



Бүртгэлийн дугаар 412

**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ, ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

**ХУУЛБАР ҮНЭН**

Хуулбар олгосон ажлын гарын үсэг

*[Signature]*

2019 оны 11 сарын 06 ний өдөр

	<p>зогсоох, орон нутгийн модны хэрэгцээг хангах ажилтай уялдуулан зохион байгуулах,</p> <p>9.Ховор, нэн ховор ургамлыг тарималжуулах ажлыг зохион байгуулах,</p> <p>10.Усны нөөцийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч хаврын шар ус, борооны усыг хуримтлуулж усан сан, хөв цөөрөм байгуулах зэрэг арга хэмжээг нутаг орны байдалд тохируулан сав газрын захиргаад болон мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор зохион байгуулах,</p> <p>11.Гадаргын болон газрын доорх ус авах барилга байгууламж, гүний худгуудын ашиглалтад хяналт тавих, тоолууржуулах, эзэн хариуцагчтай болгох ажлыг хариуцан, Сав газрын болон усны мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор зохион байгуулах,</p> <p>12.Агаарын бохирдол, хог хаягдал, химийн бодисын менежмент, био аюулгүй байдлын асуудлаар бодлогын хэрэгжилтийг хангах, агаар, ус, хөрсийг бохирдлоос хамгаалах, хяналт шинжилгээ хийх асуудлыг хариуцан зохион байгуулах, энэ ажилд Ус, цаг уур, орчны шинжилгээний албыг татан оролцуулах,</p> <p>13.Ой, хээрийн түймэр зэрэг байгалийн гамшгаас иргэдийн амь нас, байгалийн нөөц баялгийг хамгаалах, түүнд шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, хэрэгслийн нөөцтэй байх, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохин байгуулах, эко системд учирсан хохирлын талаар мэргэжлийн дүгнэлт гаргуулах, хохирлыг нөхөн төлүүлэх талаар хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллах,</p>		<p>Х,Г</p> <p>Х,Г</p> <p>Х,Г</p> <p>Х, Ш</p> <p>Х,Г</p>
<p>3 дугаар зорилтын хүрээнд</p>	<p>1.Байгалийн нөөц баялгийн талаарх мэдээллийн сангийн үйл ажиллагааг эрхлэн холбогдох байгууллага, иргэдэд байгаль орчин, аялал жуулчлалын мэдээллээр үйлчлэх,</p> <p>2.Байгаль орчин, аялал жуулчлалын талаарх хууль тогтоомж, дүрэм журмын</p>		<p>Х,Г</p> <p>Х,Г</p>




Бүртгэлийн дугаар ..... 413 .....

**ДУНДГОВЬ АЙМГИЙН**  
**ЗАСАГ, ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**  
**ХУУЛБАР ҮНЭН**  
Хуулбар олгосон ажлын гэрэн үсэг

2019 оны 09 сарын 06 ний өдөр



	<p>талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад мэдээ, мэдээлэл хийх, сургалт зохин байгуулах,</p> <p>3.Байгалийн гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад анхааруулах, ухуулга сурталчилгаа хийх,</p> <p>4.Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад байгаль дэлхийгээ хайрлах уламжлалт Монгол ёс зан заншлаа сурталчилах,</p> <p>5.Байгаль орчны судалгаа шинжилгээний ажил эрхлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжлийн байгууллага болон эрдэм шинжилгээний байгууллагатай гэрээ байгуулж, гүйцэтгүүлэх, үр дүнг хүлээн авах,</p> <p>6.Аймгийн усны нөөц түүний зохистой ашиглалт, хэрэглээний байдлыг тогтмол үнэлж, усны мэдээллийн сан байгуулах, гадаргын усны тооллого хийх, ширгэж хатсан гол, горхи, рашаан, булаг, шандын тоо, мэдээллийг гаргах, холбогдох дээд байгууллагыг мэдээллээр хангах,</p> <p>7.Аймгийн нутаг дэвсгэрт байгаа ой, ус, ургамал, ан амьтан зэрэг байгалийн нөөц баялаг, түүнээс ашиглаж болох тоо хэмжээг нарийвчлан тогтоолгох, зөвшөөрөгдсөн хэмжээнд ашиглуулах.</p>	<p>Байгаль орчин, аялал жуулчлалын улсын мэдээллийн санд жил бүр аймгийн байгаль орчны талаарх мэдээ, баримтыг хуулийн хугацаанд хүргүүлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчин, аялал жуулчлалын талаарх мэдлэг мэдээллийг дээшлүүлж, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан байна.</p>	<p>Х,Г</p> <p>Х,Г</p> <p>Х,Г</p> <p>Х,Г</p> <p>Х,Г</p>
<p>4 дүгээр зорилтын хүрээнд</p>	<p>1. Байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, санхүү, бусад нөөцийн талаар санал, төсвийн төсөл боловсруулж, батлуулах,</p> <p>2. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, хяналт тавих, үр дүнг дээшлүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах,</p> <p>3. Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, эзэмшилтэнд хяналт тавьж балансд байгаа өмч хөрөнгийг зохих журмын дагуу эзэмшиж ашиглах,</p>	<p>Төсвийн шууд захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлсэн байна</p>	<p>Г, Х, Ш</p> <p>Г, Х</p> <p>Х</p> <p>Х</p> <p>Х</p>



Бүртгэлийн дугаар 414

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ, ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

**ХУУЛБАР ҮНЭН**

Хуулбар олгосон ажлын гарын үсэг

*[Signature]*

2019 оны 11 сарын 06-ний өдөр

	<p>4. Төсвийн болон бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтыг үр ашигтай зарцуулж, хяналт тавьж ажиллах,</p> <p>5. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх, тайлагналтад хяналт тавих,</p> <p>6. Төсөв санхүүгийн болон худалдан авах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах.</p>		<p>Х</p> <p>Х, Г</p>
5 дугаар зорилтын хүрээнд	<p>1. Байгууллагын болон албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг эрх бүхий албан тушаалтнаар батлуулж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, тайлагнах, дүгнүүлэх,</p> <p>2. Байгууллагын албан хаагчдыг өдөр тутмын удирдлага, зөвлөмж, арга зүйгээр хангах, албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хяналт тавих, төрийн үйлчилгээг соёлтой шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх,</p> <p>3. Хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх,</p> <p>4. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, журмыг хэрэгжүүлэх,</p> <p>5. Гадаадын ижил, төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтоож, дэвшилтэд техник, технологийг ажилдаа нэвтрүүлэх арга хэмжээ авах</p> <p>6. Албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх, стандартыг хэрэгжүүлэх.</p> <p>7. Иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг судлан шийдвэрлэх ажлыг зохион байгуулах.</p> <p>8. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангаж, сургаж чадавхижуулах ажлыг зохион байгуулах</p> <p>9. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх</p>	<p>Гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилтууд хангагдсан байна</p> <p>Байгууллагын болон мэргэжилтнүүдийн чиг үүрэг бүрэн хэрэгжсэн байна.</p> <p>Хүний нөөцийн бодлого, түүний хэрэгжилт хууль тогтоомжид нийцсэн байна.</p> <p>Стандарт хангагдсан байна.</p> <p>Өргөдөл, гомдлыг хуулийн хүрээнд шийдвэрлэсэн байна</p> <p>Сургалтын болон нийгмийн баталгаа хангах хөтөлбөр хэрэгжсэн байна</p> <p>Хууль тогтоомжид заасан чиг үүрэг бүрэн хэрэгжсэн байна.</p>	<p>Х,Ш</p> <p>Г, Х</p> <p>Г, Ш</p> <p>Х</p> <p>Х, Ш</p> <p>Х</p> <p>Г, Х</p> <p>Г, Х</p>



Бүртгэлийн дугаар ..... 415

**ДУНДГОВЬ АЙМГИЙН**  
**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**  
**ХУУЛБАР ҮНЭН**  
Хуулбар олгосон ажлын гарын үсэг

*[Signature]*

2019 оны 01 сарын 06 ний өдөр

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА	
Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй
Мэргэжил	Байгалийн шинжлэл, хүрээлэн буй орчин, хүрээлэн буй орчныг хамгаалах технологи, ойн аж ахуй, аялал жуулчлал.
Мэргэшил	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх
Туршлага	Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх;
Ур чадвар	Удирдан зохион байгуулах <ul style="list-style-type: none"> <li>-байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, гүйцэтгэлийг дүгнэх, тайлагнах шаардлага тавьж чаддаг байх;</li> <li>-удирдлагадаа байгаа албан хаагчдын ажил үүргийг оновчтой тэнцвэртэй хуваарилах, удирдах;</li> <li>-үйл ажиллагаан дахь эрсдэлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;</li> <li>-албан хаагчдын санал, бодлыг сонсох, бүтээлч санаачилга, зөв хандлагыг дэмжих;</li> <li>-албан хаагчдын ажлын гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж, хуульд нийцсэн заавар чиглэл өгөх;</li> <li>-үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;</li> <li>-бусад.</li> </ul>
	Дүн шинжилгээ хийх <ul style="list-style-type: none"> <li>-судалгааны дүн, мэдээлэлд тулгуурлан бодлого боловсруулах;</li> <li>-тоон мэдээлэлтэй ажиллах, нэгтгэн дүгнэх, статистикийн арга хэрэгслийг ашиглах чадвартай байх;</li> <li>-судалгааны үр дүн, шийдлийн хувилбарын шууд ба шууд бус үр дагаварыг харьцуулан үнэлж, зөвлөмж боловсруулах;</li> <li>-бусад,</li> </ul>
	Асуудал шийдвэрлэх <ul style="list-style-type: none"> <li>- хууль тогтоомжид нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдлийг шуурхай гаргах;</li> <li>-тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах;</li> <li>-албан үүргээ хууль тогтоомж, ёс зүйн зарчимд нийцүүлэн, ашиг сонирхлоос ангид гүйцэтгэх;</li> <li>- бусад.</li> </ul>
	Манлайлах <ul style="list-style-type: none"> <li>-ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч чанараараа бусдыг үлгэрлэх;</li> <li>-шинэлэг санаа, шинэ санаачилга, бүтээлч хандлагыг дэмжих;</li> </ul>



		-байгууллага, нэгжийн үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх; -аливаа шийдвэрийг гаргахдаа хамт олны саналыг тусгах; -хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх; -бусад.
	Бусад	- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; -албан бичиг боловсруулах, албан хэрэг хөтлөх; -мэдээллийг шуурхай хүргэх, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх; -багийн ажлын амжилтыг үнэлэх, дэмжих, бусдад таниулах, нээлттэй харилцааг бий болгох.

#### IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Аймгийн Засаг дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо

Бусад харилцах субъект

- Ахлах мэргэжилтэн .....
- Мэргэжилтэн .....
- Байгаль хамгаалагч .....
- Төрийн үйлчилгээний албан хаагч .....

Нийт ..... /тоо/

- БОАЖЯамны холбогдох нэгжийн дарга, албан хаагч,
- Аймгийн ИТХ-ын дарга, Тэргүүлэгч, нарийн бичгийн дарга,
- Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн,
- Төрийн болон төрийн бус байгууллага,
- Иргэн, хуулийн этгээд.

#### V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 19 09 13

Дугаар: 63



Бүртгэлийн дугаар 417

ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР  
ХУУЛБАР ҮНЭН  
Хуулбар олгосон үйлдлийн гарын үсэг

2019 оны 11 сарын 06 ний өдөр

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)  
20... оны ... дугаар сарын ... -ны өдөр

**VI. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:**

Байгууллагын нэр:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2019.11.05

Дугаар: А/395

(Тамга/ тэмдэг)

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА: *[Signature]* О. Бат-Эрдэнэ

Гарын үсэг (Эцэг/эхийн нэр, өөрийн нэр)

2019 оны 11 дугаар сарын 05-ны өдөр



Бүртгэлийн дугаар 418  
ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР  
ХУУЛБАР ҮНЭН  
Хуулбар олгосон өмчлөлийн гарын үсэг  
*[Signature]*  
2019 оны 11 сарын 06-ний өдөр